



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 23 өдөр

Дугаар A/137

Жаргалтхаан сум

**Мотоциклийн хөдөлгөөнийг түр
хугацаагаар хязгаарлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Хүйтний улирал эхэлж сумын хэмжээнд цас ихээр орж халтиргаа, гулгаа үүсэж замын хөдөлгөөнд оролцогчдод хүндрэл учруулж болзошгүй байгаа тул иргэдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах зорилгоор 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрөөс 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл мотоциклиор замын хөдөлгөөнд оролцохыг түр хугацаагаар хязгаарласугай.

2. Иргэдэд замын хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай анхааруулга, сэрэмжлүүлэг өгч сурталчлах ажлыг зохион байгуулж ажиллахыг Сум дундын Цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч Д.Хүрэлбаатар, Замын зохицуулагч, цагдаагийн дэслэгч Б.Мөнх-Эрдэнэ нарт даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга С.Мөнхдэлгэрт даалгасугай.

ДАРГА



Л.ЦЭНГЭЛ

Data (D:) /A4 zahiramj/

• 232401043